

## PLITONIT PlitoFlex 5000 – Хэт том хавтан суурилуулах зориулалттай загаан өнгөтэй маш өндөр уян цавуу



Бүх төрлийн зүсмэл хавтан, шавар хавтан, нэг талыг нь хүчтэй шахалтад оруулсан хавтан, хиймэл болон байгалийн чулуун хавтан, түүний дотор (том хэмжээтэй 180 см болон түүнээс дээш) бетон, төмөр бетон, хөнгөн бетон, тоосго, цементэн болон бусад шавардлага, гипсэн хавтан, цементэн хавтан, бүх төрлийн будагтай гадаргуу, хана болон бүтцийн гажилттай суурь, ЦСП, ДСП зэрэг гадаргуу дээр наан өнгөлж дотор болон гадна ажил гүйцэтгэх зориулалттай. Шалны халаалтын систем дээр шууд хийж, гүйцэтгэх боломжтойгоос гадна бүх төрлийн хэмжээтэй усан сангийн өнгөлгөөнд ашиглах боломжтой. Бүтээгдэхүүний уян хатан чанар нь суурийн гадаргуу болон хавтан хоорондын бүтцийн болон агаар, орчны хэмээс үүдэлтэй ачааллыг багасгаж өгдөг. Бүх төрлийн хэцүү (Уян болон эрдэс ус чийг тусгаарлах материал дээр болон хавтанцар дээр хавтанцар (хавтан дээр хавтан)) гажилт бүхий гадаргуу дээр наах боломжтой. Нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, тэр дундаа сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууламж (эмчилгээ, урьдчилан сэргийлэх, амралт-сувиллын байгууламжууд)-д хэрэглэж болно.

### Савлагаа — 20 кг

- ангилал C2 E S2
- Барьцалдах чадвар 2.5 МПа -аас багагүй
- Хэт том дурын хэмжээний хавтанд зориулсан
- цементэн үртсэн хавтан, модон үртсэн хавтан, шүлтэд тэсвэртэй будаг болон бусад нарийн төвөгтэй суурийн хувьд
- ямар ч хэмжээтэй усан санд хавтан наахад

### Бүтээгдэхүүний зарцуулалт

1 мм зузаантай гүйцэтгэх үеийн зарцуулалтын хэмжээ нь 1,04 кг/м<sup>2</sup>

### Хэрэглэх зөвлөмж

Бүх төрлийн хэцүү гадаргуу дээр (бүх төрлийн шүлтэд тэсвэртэй будагтай гадаргуу, хана болон шалны хуучин чулуун суурьтай плита, цементэн суурьтай үртсэн хавтанцар болон хулдаас, ПВХ хавтанцар, будгийн бүрэлтийн үлдэгдэл дээр ч) наах чадвартай. Угаалгын өрөө, шүршүүр болон саунд WATERPROOF PREMIUM, ГИДРОЭЛАСТ, WATERPROOF STANDARD зэрэг ус тусгаарлалтын материал дээр гүйцэтгэж болно. Шалны халаалтын систем, ашиглалт өндөртэй хэсэг болон тогтмол чичирхийлэлтэй шал дээр гүйцэтгэх боломжтой.

Энэ нь өргөн хүрээний хэрэглээтэй, өндөр технологитой, үс, хүйтэнд тэсвэртэй, хэрэглэхэд хялбар, усанд амархан холилддог, уян хатан чанарыг нь илүү сайжруулсан. ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 56387 стандарт С2 Е S2 ангиллын нэмэлт шаардлагыг хангасан: зуурмагийн ашиглалтын хугацаа урт, дурын орчин дахь (хуурай агаар орчинд, усанд, хүйтэнд болон хэт өндөр дулааны үед) уян чанар өндөр бүтээгдэхүүн.

### **Ажлын нөхцөл**

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших З хоногт агаарын температур, суурийн болон хавтангийн температур +5 °C-аас +30 °C хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн температур +10°C-аас +30°C хүртэл байх нь зохимжтой. Гаднах ажлын гүйцэтгэлийн үед хур тунадаснаас хамгаалах шаардлагатай.

### **Гадаргууг бэлтгэх**

Гадаргуу нь бат бэх байх шаардлагатай, ажил эхлэхээс өмнө гадаргууг сайтар цэвэрлэх (тоос, широо, шохой, тос болон тослог гадаргуу, битум, органик болон эрдэс бүхий наалдамхай бодис, будгийн үлдэгдэл, түүнчлэн усанд уусдаг бодис) шаардлагатай. Гипсэн суурь гадаргуу болон үс шингээх чадвар өндөртэй гадаргууг өнгөлөхдөө үйлдвэрлэгчийн зааврын дагуу ажил эхлэхийн өмнө PLITONIT хөрсжүүлэгчээр бүрсэн байх шаардлагатай. Цаашдын ажлыг хөрсжүүлэгч бүрэн хатсаны дараа гүйцэтгэнэ.

### **Зуурмагийн хольц бэлтгэх**

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн үндны үсыг ашиглана. Холих харьцаа нь хуурай цавууны хольцод 1 кг-д 0,22-0,26 литр (20 кг-д 4,4 - 5,2 литр) үс шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний үс руу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш цахилгаан холигч эсвэл цахилгаан ёрмийн тусламжтайгаар холино (эргэлтийн хурд нь 600 эрг/мин-ээс ихгүй байна). Зуурмагийг ойролцоогоор 5 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн үсыг нэмж хэрэглэж болно. Бэлэн зуурмагийг хэрэглэх хугацаа нь 8 хүртэлх цаг байх бөгөөд агаарын хэт халалт болон нэвт салхижуулалт энэ хугацааг багасахад нөлөөлнө.

### **Ажлын дараалал**

Бэлтгэсэн зуурмагийг суурийн гадаргуу дээр жигд тараан, гөлгөр хусуураар түрхэж ховилтой хусуураар долгион гаргах байдлаар түрхэнэ (ховилын хэмжээ нь хавтангийн хэмжээ, төрлөөс хамаарна). Зуурмагийг асгаснаас хойш 40 минутын (ажил гүйцэтгэх хугацаа) дотор өнгөлгөөний хавтанг наах боломжтой байдлаар тооцон гүйцэтгэнэ. Хавтанг зуурмаг дээр тавихдаа бага зэрэг эргүүлэх байдлаар сайн дарж тавина. Хавтангийн байрлалыг 40 минутын дотор засан тохируулж болно. Өрөөний агааржуулалт, дулаан, гадаргуун чийг шингээх чадвараас шалтгаалан дээрх хугацаа өөрчлөгдж болно. Хэрэв хэрэглэсэн цавууны гадаргуу дээр хатсан царцdas үүссэн бол зуурмагийг гадаргуугаас хусаж аван шинээр сольж хийх шаардлагатай. Хавтан нь нээлттэй залгалтаар тавьж, зохих бэхэлгээгээр тэгшилнэ. Усан сан, байгууламжийн нүүрэн тал, террас, тагт, халдаг шал, түүнчлэн арын овгорын өндөр нь 2 мм-ээс дээш эсвэл 30x30 см-ээс дээш хэмжээтэй хавтангуудаар өнгөлгөө хийх үед хавтангийн доорх хоосон зайнласийх, наалдуулах бат бэх чанарыг нэмэгдүүлэхийн тулд хосолсон байдлаар (суурь ба хавтангийн ар талд) цавуу түрхэх шаардлагатай. Цавууг дээр дурдсанчлан суурь дээр хэрэглэнэ. Хавтангийн арын хэсэгт цавууг эхлээд ховилтой хусуураар түрхэж, дараа нь гөлгөр хусуураар хавтангийн бүх хэсэгт жигд тэгшилнэ. Тус хосолсон хэлбэрээр зуурмагийг ашиглах үед зарцуулалт нь 1 мм зузаантай түрхэхэд 1.04 кг/m<sup>2</sup> болж нэмэгддэг.

**Том хэмжээтэй хавтан сууринуулах үеийн зөвлөмж.** Цавуу түрхэхдээ хосолсон аргыг хэрэглэнэ. Цавуу түрхэхэсээ өмнө хавтангийн ар тал нь цэвэр, тоосгүй эсэхийг шалгаарай.

Шаардлагатай бол чийгтэй хөөсөнцрөөр арчиж цэвэрлэнэ. Цавуугаар илүү сайн норгохын тулд налуу ховилтой хусуураар цавууг гадаргуу дээр түрхэн хэрэглэхийг зөвлөж байна. Хавтангийн арын хэсэгт түрхэхдээ гадаргуугийн бараг 100% нь цавуугаар норсон байхын тулд З мм-ийн нарийн ховилтой хусуур ашиглана. Цавууг хавтангийн богино талтай зэрэгцүүлэн шулуун туш шугамын дагуу түрхэнэ. Цавууг суурь болон хавтан дээр нэг чиглэлд түрхэнэ. Цавууны хажуу тал хоорондоо давхцахаар хавтанг хэзээ ч бүү тавь. Давхар түрхэх аргыг ашиглан цавуу түрхсэний дараа хавтантай ажиллахад аль болох хялбар, аюулгүй байхын тулд чиглүүлэгч, хөндлөвч, эсвэл сордог бариул ашиглахыг зөвлөж байна. Хавтанг сууринд илүү сайн наалдуулахын тулд хавтангийн гадаргууг чичрүүлэгч багажаар явуулах алхах эсвэл тусгай резинэн хусуур ашиглан гараар цохиж өгөх хэрэгтэй. Хавтангийн доороос бүх агаарыг зайлуулахын тулд хавтангийн төвөөс ирмэг хүртэл богино тал уруу параллелиар товш.

### Анхааруулга

Өнгөлгөөний хавтанг гадаргуу дээр байрлуулснаас хойш 24 цагаас багагүй хугацааны дараа дээгүүр нь алхах, чижээс хийж болно. Шалны халаалтыг ажиллуулахыг үс чийгт тэсвэртэй хавтан дээр хийсэн тохиолдолд хавтанг нааснаас хойш 3-аас багагүй хоногийн дараа энэ үйлдлийг хийхийг зөвшөөрнө. Дээр заагдсан хугацаа нь орчны температур ( $20\pm2$ )°C, агаарын харьцангуй чийгшил ( $60\pm10$ )-д үйлчлэх бөгөөд бусад үед хугацаа хэлбэлзэж болно. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстай. Хавтанг тавихаас өмнө дэвтээж болохгүй, хавтангийн арын хэсгийг тоос, шорооноос цэвэрлэх хэрэгтэй. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстай. Бэлэн зуурмаг дээр нэмж үс хийхийг хориглоно. Зуурмагийн өнгө өөр байх нь тухайн бүтээгдэхүүний түүхий эдийн олборлолтоос шалтгаалах бөгөөд энэ нь бүтээгдэхүүний техник үзүүлэлт болон ашиглалтын шаардлагад нөлөөлөхгүй. Найрлагад бага хэмжээний бэхжүүлэх утас агуулсан байж болно.

### Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГААРАЙ.

### Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хуурай өрөөнд хадгална. Үйлдвэрлэгчийн саванд хадгалах хугацаа нь тээвэрлэх, хадгалах нөхцөл зөрчигдөөгүй үед үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

### Орц, найрлага

Портландцемент, нарийн ширхэгтэй элс, холбогдох нэмэлт бүтээгдэхүүнүүд.

### Техник үзүүлэлтүүд

Дүүргэгчийн хамгийн том ширхгийн хэмжээ	0,63 мм
Цавууны үеийн хамгийн их залгааны зузаан	15 мм
1 кг хольцод хэрэглэх үсны хэмжээ	0,22-0,26 л
20 кг хольцод хэрэглэх үсны хэмжээ	4,4-5,2 л
Нээлттэй ажиллах хугацаа	40 минут
Хавтанг засах, тохируулах хугацаа, багагүй	40 минут
Зуурмаг хольцын амьдрах чадвар	8 цаг
Ашиглалтын үеийн температурын горим	-50°C-аас +100°C хүртэл
Хөндлөн гажилт	≥5,0 мм
Зуурмагийн хүйтэнд тэсвэртэй байдлын марк, багагүй	F150 багагүй

Дээгүүр нь явж болох хугацаа, дараа	24 цаг
Хуурай агаарт 28 хоногийн турш байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал.	$\geq 2,5$ МПа
Гадаргуутай бат бэх барьцалдах нээлттэй хугацаа	$\geq 1,8$ МПа
+100°C -ийн өндөр температурт байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал	$\geq 2,5$ МПа
Усан орчинд байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал	$\geq 1,0$ МПа
Циклээр хөлдөөх ба гэсгээсний дараа цавууны барьцалдах бат бөх байдал	$\geq 1,0$ МПа

**Логистикийн мэдээлэл**

Хувийн бар-код 4607013048416

Нэг багц дахь уутны тоо – 48 ширхэг